

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 3 сарын 23 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

## Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дах заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

- Компанийн 2023 оны санхүүгийн тайланд хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



*Ч. Чинзориг*

Ч.ЧИНЗОРИГ

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 3 сарын 23 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

## Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дах заалт болон Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг Хавсралт №1-р баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



*Ч.Чинзориг*

Ч.ЧИНЗОРИГ

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 3 сарын 23 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

## Хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2, 38 дугаар зүйлийн 38.8, 42 дугаар зүйлийн 42.1, 53 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.3 дэх заалт, 87 дугаар зүйлийн 87.1.1 заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

- Компанийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, зах зээлд эзлэх байр суурийг бэхжүүлэх үүднээс 491,883,292 ширхэг энгийн хувьцааг хаалттай хүрээнд стратегийн хөрөнгө оруулагч болох Шинтани Такаёшид эзэмшүүлэхээр нэмж гаргасугай.
- Хаалттай хүрээнд нэмж гаргаж байгаа хувьцааны үнийг Монголын хөрөнгийн биржийн арилжааны сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшийг харгалзан нэг бүр нь 19.60 төгрөгөөр тогтоосугай.
- Компанийн тухай хуулийн 38.8-д заасны дагуу тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар тогтоосугай.
- Хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргаж байгаатай холбоотой асуудалд санал хураалтад оролцоогүй буюу эсрэг саналтай хувьцаа эзэмшигчийн хувьцааг компаниас эргүүлэн худалдаж авах эрхийг хэрэгжүүлэхийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.
- Хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргахтай холбоотой ажлыг хийж гүйцэтгэх бүрэн эрхийг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 3 сарын 23 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

## Компанийн шинэчилсэн дүрмийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 31 дүгээр зүйл 31.2.2 дэх заалт, 33 дугаар зүйл 33.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 10 тоот тогтоолын 2.2.5 дах заалт, Тандэм Инвэст ХК-ийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

- Компани хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргахтай холбогдон компанийн нийт гаргасан хувьцааны тоог 2,000,000,000 ширхэг болж нэмэгдэж, хувь нийлүүлсэн хөрөнгө 4,600,000,000 /Дөрвөн тэрбум зургаан зуун сая төгрөг / болж байгаа тул компанийн шинэчилсэн дүрэмд өөрчлөлтийг тусгасугай.
- Компанийн нийт энгийн зарласан хувьцааны тоог 5,000,000,000 ширхэг болгон нэмэгдүүлж компанийн шинэчилсэн дүрмийг Хавсралт №1-ээр баталсугай.
- Дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 3 сарын 23 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

## Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн батлах

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дах заалт Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

- Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг хавсралт №1-р баталсугай.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

## Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсөв батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15 дах заалт Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

- Тандэм Инвэст ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг Хавсралт №1-р баталсугай.
- Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хороонд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ